



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 4/401

Ховд

Г Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоол, "Иргэний эрх зүйн боловсрол" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт /4.4.2.2/-ыг хэрэгжүүлэх зорилгоор "Хууль журам миний амьдралд" аяны хүрээнд "Эрх зүйн боловсролыг иргэн бүрт" сэдэвт аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.
2. Аяны удирдамжийг хавсралтаар баталсугай.
3. Аяны хүрээнд удирдамжид заагдсан ажлыг "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр", "Иргэний эрх зүйн боловсрол" аймгийн дэд хөтөлбөртэй уялдуулан бүтээлчээр зохион байгуулж, үр дүнг улирал, хагас бүтэн жилээр тооцон дүгнэж байхыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга наарт үүрэг болгосугай.
4. Аяны үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үр дүнгийн талаарх мэдээллийг Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс /Н.Ганзориг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/401 Ch
02 01992

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар
сарын 25-ны өдрийн А/401 дүгээр
захирамжийн хавсралт



УДИРДАМЖ

“Хууль журам миний амьдралд” аяны хүрээнд
явагдах “Эрх зүйн боловсролыг иргэн бүрт”
сэдэвт аяны тухай

Нэг. Үндэслэл, зорилго:

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2-т заасан “хууль тогтоомжийг сурталчилах, тайлбарлан таниулах, эрх зүйн сургалт сурталчилгаа мэдээллийн ажлыг тогтмол явуулж, иргэдийн нийгмийн амьдралд оролцох эрх үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ”, 4.4.2.2-т заасан “Хууль журам миний амьдралд” аяны хүрээнд хууль эрх зүйн мэдээлэл түгээх ажлыг иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэдийн эрх зүйн мэдлэг, соёлын түвшинг ахиулна” гэсэн зорилтуудыг хэрэгжүүлэх, “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Хоёр. Хамрах хүрээ:

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний сум, баг, байгууллагууд

Гурав. Зохион байгуулагдах хугацаа:

Аяныг 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулна.

Дөрөв. Аяны хүрээнд хийх ажлууд

4.1. Сумын Засаг дарга, Тамгын газар

а.Сумын хэмжээнд аяныг “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн дэд хөтөлбөртэй уялдуулан хариуцан зохион байгуулах ажлын хэсэг томилон, төлөвлөгөө гарган, иргэд төрийн албан хаагчдыг өргөнөөр оролцуулан аяны нээлт хийж зорилго, үйл ажиллагаагаа таниулан, төрийн байгууллага, албан хаагчдад үүрэг чиглэл өгөх

б.Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх болон хүний эрх, эрх чөлөөний тухай ойлголт, мэдлэг олгох сургалт сурталчилгааг байнга хийх

в.Шинээр батлагдан гарч буй хуулиудын талаарх мэдээлэл, сурталчилгааг тогтмол хийх

г.Эрүүгийн болон зөрчлийн тухай хууль, иргэний хууль, төрийн албаны тухай, хөдөлмөрийн тухай, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, боловсролын багц хуулиудыг судлах, сурталчлах, дээрх хуулиудын хүрээнд нийцүүлэн гаргасан журмуудыг сурталчилах, мөрдөж хэрэгжүүлэх ажлыг тусгайлан зохион байгуулах

д.“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай” хуулиудыг тайлбарлан таниулах, гарын авлага бэлтгэж түгээх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг сургалтанд хамруулах замаар хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг багасгах, арилгахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллах

е.Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, байгаль орчны холбогдолтой хууль, журмуудыг сурталчилж ажиллах, иргэдийн мэдлэг хандлага, боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах

ё. Захиргааны ерөнхий хуулийг иргэдэд сурталчилан захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх

ж.Зорилтот бүлгийн хүмүүсийг хууль, эрх зүйн сургалтанд хамруулах, мэдлэгийг дээшлүүлэх

з. Хууль, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны e-khutuch.mn цахим хуудсыг олон нийтэд сурталчлах

4.2. Байгууллагууд

а.Төрийн албаны нэр хүндийг дээшлүүлэх, албан хаагчдын ёс зүйтэй, хариуцлагатай байдал, байгууллагын соёл, дэг журам, төрийн ажил үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж иргэдэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, иргэдийг тухайн салбарын мэдээллээр хангахад чиглэсэн бодитой ажлууд зохион байгуулж хэвшүүлэх

б.Хүний эрх эрх чөлөөний тухай ойлголт, мэдлэг олгох сургалт сурталчилгааны хөтөлбөр гарган хэрэгжүүлэх

в.Байгууллагын хэмжээнд “Иргэний эрх зүйн боловсрол” хөтөлбөр, гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх, тамхины

хяналтын тухай болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн холбогдох бусад хуулиудыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, үр дунг тооцох

г.Захиргааны ерөнхий хуулийн хэм хэмжээг баримтлан захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах хуулийн шаардлагыг хэрэгжүүлж ажиллах

д.Тодорхой түвшний эрх зүйн мэдлэг эзэмшсэн хамт олон болж, үүнийгээ үнэлүүлэн баталгаажуулахад чиглэсэн санал, санаачилга өрнүүлэх арга хэмжээг зохион байгуулах

е.Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжигч, бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох үүргээ сайн хэрэгжүүлсэн талаарх байгууллага, хамт олны үйл ажиллагаагаа сурталчлах ажлыг зохион байгуулах.

Тав. Аяны дүн гаргах

1. Аяны хугацаанд хийж гүйцэтгэх ажилд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ба сум, байгууллагууд аяны хугацаанд хийсэн ажлынхаа мэдээ мэдээллийг улирлаар, нэгдсэн тайлан мэдээг 2019 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлнэ.

2. Хууль, эрх зүйн хэлтэс аймгийн хэмжээнд хийгдсэн аяны ажлын дүн мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын Зөвлөлд танилцуулна.

-оо-